

# ДОТООДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ



## Дотоодын зах зээлийн онцлох мэдээ

## ТОВЧ

- Премиум Нэксус ХК хувьцааны I ангилалд орлоо
- 2026 оны I улиралд бодлогын хүү 11.4% болох магадлалтай
- Хаан банкны өдрийн арилжааны идэвхи хамгийн өндөр байна
- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш оны эцэст 3,612₮ болно

## МХБ-ийн индексийн өгөөж

Индекс	Долоо хоног	Сар	Жил
ТОП 20	1.21%	-0.71%	25.47%
MSE A	1.46%	-1.21%	20.27%
MSE B	0.72%	-0.21%	34.89%

2025/09/01 – 2025/09/05

## Идэвхтэй арилжаалагдсан үнэт цаас

Симбол	Үнийн дүн
INV	797,854,550.00
ТАН	793,921,240.00
КХАН	559,789,752.00
DZG	245,823,840.00
TTL	180,221,580.00

2025/09/01 – 2025/09/05

## Өндөр өсөлттэй үнэт цаас

Симбол	Хаалтын ханш	Өсөлт %
HRM	200.00	14.28%
AMT	8.98	10.86%
ТАН	18,500.00	8.82%
TGI	749.90	6.52%
GOV	254.85	5.52%

2025/09/01 – 2025/09/01

2025 он 09-р сарын 08

Зах зээлийн  
үнэлгээ тэрбум ₮

12,311

ТОП-20 индекс

48,980

MSE A

18,258

MSE B

14,569



## МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ДНБ өсөлт

5.6%

2025 - II улирал

Инфляц

8.1%

2025-07 сар

ГВУН(сая\$)

5,683.43

2025-08 сар

Бодлогын

хүү

12.0%

ЗГ-ын бондын

өгөөж

6.6%

USD/MNT

3,593.69

2025-09-07

## ЭДИЙН ЗАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

### МОНГОЛ БАЗАЛТ ХК, ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИУД ХУВЬЦААНЫ АНГИЛАЛАА ДЭЭШЛҮҮЛЭВ

Монголын хөрөнгийн бирж хувьцааны компаниудыг I, II, III ангилалд хуваадаг. Энэ нь тухайн компанийн санхүүгийн үзүүлэлт, засаглалын түвшин, мэдээллийн ил тод байдал зэрэг шалгуур үзүүлэлтээс хамаардаг бөгөөд хөрөнгө оруулагчдад эрсдэл, боломжийг ялгаж харах чухал дохио болдог. Өнгөрөгч долоо хоногт зарим компанийн ангилалд дараах өөрчлөлтүүд орлоо.

Дэвшсэн компаниуд (II-оос I ангилалд):

[MSE:CUMN] Премиум нэксус ХК

[MSE:MBW] Монгол базальт ХК

[MSE:MLG] Монложистикс холдинг ХК

Буурсан компаниуд (I-ээс II ангилалд):

[MSE:TCK] Талх чихэр ХК

[MSE:GAZR] Газар шим үйлдвэр ХК

[MSE:MMX] Махимпекс ХК

[MSE:BODI] Бодь даатгал ХК

Эдгээр компаниуд санхүүгийн үзүүлэлтээ сайжруулж, ил тод байдлаа хангаж, хөрөнгийн зах зээлийн шаардлагыг биелүүлснээр дээд шатны ангилалд багтаж байна. Ийнхүү ангиллын өөрчлөлт нь хөрөнгө оруулагчдад компаниудын чанар, түвшнийг илүү бодитой үнэлэх боломж олгодог бөгөөд компанийн өөрийн хувьд илүү өндөр ангилалд багтах нь нэр хүнд, хөрөнгө татах чадавхыг нэмэгдүүлдэг чухал үзүүлэлт юм.

### 2025 ОНЫ III УЛИРЛЫН ШИНЖЭЭЧДИЙН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨСӨӨЛӨЛ

Монгол Банкнаас улирал бүр дотоодын шинжээчдийн дунд явуулдаг макро эдийн засгийн 2025 оны 3-р улирлын төсөөллийг хүргэж байна.

2025 оны III улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.3%
- Эдийн засгийн өсөлт 5.4%
- Бодлогын хүү өнөөгийн түвшинд 12.0%
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.2%

2026 оны II улиралд

- Инфляц өнөөгийн түвшинд 9.1%
- Эдийн засгийн өсөлт 5.1%
- Бодлогын хүү бага зэрэг буурч 11.4%
- Зээлийн хүү өнөөгийн түвшинд 17.1%

2025 оны эхний хагас жилийн байдлаар Улаанбаатар хотын жилийн инфляц 9.3% болж өмнөх улирлын шинжээчдийн таамгаас 0.5 нэгж хувиар доогуур гарлаа. Шинжээчид III улиралд инфляц 9.3%, нэг жилийн дараа 9.1% орчим байна гэж үзэж байна. Таамаглалын тархалтаар III улиралд инфляц 9.0–9.9% байх магадлал хамгийн өндөр буюу 30.4%, 8.0–8.9% байх магадлал 24.1% байна. Өмнөх улиралд энэ магадлалын үнэлгээ 24.4% байсан юм.

2025 оны II улиралд бодит ДНБ-ий жилийн өсөлт 5.6% гарч, өмнөх таамгаас 2.6 нэгж хувиар өндөр үзүүлэлттэй байлаа. Шинжээчид III улиралд өсөлт 5.4%, 2026 оны II улиралд 5.1% байна гэж таамаглаж байна.

Таамаглалын тархалтаар III улиралд өсөлт 5.0–5.9% байх магадлал хамгийн өндөр буюу 30.6% байгаа бол өмнөх улиралд өсөлт 3.0–3.9% байх магадлал хамгийн өндөр буюу 26.4% гэж тооцож байжээ. Ингэснээр шинжээчдийн ДНБ-ий өсөлтийн хүлээлт мэдэгдэхүйц нэмэгдэж, цаашид энэ түвшинд тогтворжих төлөвтэй байна.



## Зах зээлийн мэдээлэл

### ТОП-20 ИНДЕКС ОН ГАРСНААС ХОЙШ 6.23% УНАЛАА


График 2. ТОП-20 индексийн ханшийн өөрчлөлт



ТОП-20 индекс 2025 он гарснаар 6.23 хувиар унаад байна. Компаниудын орлого эхний хагас жилд өссөн ч гэсэн цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байлаа. Ханш 46,300 түвшин рүү үргэлжлэн унах магадлал өндөр бөгөөд 46,300 хүчтэй дэмжлэгийн бүс болж байна. Энэ оны сүүлийн улиралд индекс хүчтэй өсөх магадлалай.

### ХААН БАНКНЫ ӨДРИЙН ДУНДАЖ АРИЛЖААНЫ ИДЭВХИ ХАМГИЙН ӨНДӨР БАЙНА

График 3. 2025 он гарснаао хамгийн өндөр арилжааны идэвхитэй компаниуд




## ДОТООДЫН ХУВЬЦААНД ХЭЗЭЭ ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ВЭ?

ТОП-20 индексийн хэлбэлзэл (2015-2025)

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023	2024	2025	ДУНДАЖ
1 сар	-2.10%	-1.00%	5.40%	-4.20%	7.50%	0.90%	10.50%	1.90%	3.50%	7.00%	2.90%	2.90%
2 сар	-3.50%	-3.00%	-0.90%	-0.10%	-0.60%	-0.90%	29.20%	-4.60%	2.40%	5.50%	1.70%	2.30%
3 сар	-3.50%	-5.10%	4.60%	-1.00%	-2.60%	-4.00%	31.20%	-6.10%	0.50%	1.90%		1.60%
4 сар	-3.00%	-1.50%	2.50%	-4.60%	-3.70%	-8.70%	4.10%	-0.90%	-5.20%	-3.30%		-2.40%
5 сар	-2.40%	-1.20%	-1.60%	-2.00%	0.30%	-2.10%	1.20%	-6.70%	0.50%	-0.40%		-1.40%
6 сар	13.90%	5.20%	-1.60%	0.90%	-1.80%	-1.00%	-7.70%	-3.70%	-0.60%	0.80%		0.50%
7 сар	-2.60%	10.80%	8.20%	-1.00%	3.60%	2.00%	-1.10%	-0.80%	1.10%	9.80%		3.00%
8 сар	-6.70%	-1.80%	8.70%	-0.90%	-2.80%	1.60%	7.70%	4.60%	0.00%	3.50%		1.40%
9 сар	-0.40%	-7.40%	16.60%	3.50%	-3.20%	2.70%	27.50%	-1.50%	-5.40%	-1.30%		3.10%
10 сар	-0.60%	-2.70%	16.90%	2.10%	-3.60%	1.60%	-10.00%	-1.90%	0.60%	0.20%		0.30%
11 сар	-2.90%	-3.40%	9.30%	-2.00%	0.00%	0.50%	-2.40%	1.10%	4.60%	1.80%		0.70%
12 сар	-3.60%	7.00%	0.10%	0.10%	1.90%	3.30%	5.80%	5.40%	5.00%	2.00%		2.70%

ТОП-20 индексийн сарын дундаж хэлбэлзэл (2015-2025)



Монголын ТОП-20 индексийн дундаж хэлбэлзлээс харахад 1-3 сар, 7-9 сар, 12 саруудад өсөлт давамгайлдаг байна.

### Ямар стратеги баримтлах вэ?

- Ногдол ашиг хүртэхийг зорьж буй бол 1-3 сард хувьцаа худалдаж авах нь тохиромжтой.
- Хямд үнээр хувьцаа авах боломж хайж байгаа бол 4-5 сард зах зээлийн уналтыг ашиглах хэрэгтэй.
- 7-9 сард зах зээл өсөх магадлалтай тул эрт худалдан авч, өсөлтийг ашиглах боломжтой.
- Жилийн эцэст (12-р сар) дунд хугацааны өсөлт ажиглагдах хандлагатай тул урт хугацааны хөрөнгө оруулалтад тохиромжтой үе.